

## 2020 оны эхний 7 сард

### Агаарын тээвэр



	2019 I-VII	2020* I-VII	
Зорчигчид, мян хүн (Давхардсан тоогоор)	877.9	324.0	
Тээсэн ачаа, ТОНН	3 177.8	1 559.4	
Тээврийн орлого, тэрбум төг	279.8	80.8	

### Төмөр замын тээвэр



	2019 I-VII	2020* I-VII	
Зорчигчид, мян хүн (Давхардсан тоогоор)	1 540.9	1 142.5	
Тээсэн ачаа, мян.ТОНН	15 561.5	16 905.0	
Тээврийн орлого, тэрбум төг	401.9	437.8	




## ТЭЭВЭР

### ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР

Төмөр замын тээврээр 2020 оны эхний 7 сард 16.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.3 (8.6%) сая тонноор өсжээ.

Төмөр замын тээврээр тээсэн ачаа, мянган тонн, сараар



Төмөр замын тээврээр тээсэн ачааны өсөлтөд экспортын ачаа 1.3 (22.6%) сая тонн, дамжин өнгөрөх ачаа 84.2 (3.7%) мянган тонноор тус тус өссөн нь нөлөөлсөн байна.


Төмөр замын тээврээр тээсэн ачаа 2020 оны 7 дугаар сард 2.5 сая тонн болж, өмнөх сараас 152.4 (6.4%) мянган тонноор өсжээ.

Төмөр замаар тээсэн ачаа, бүтээгдэхүүний бүлгээр, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эхний 7 сараар

Үзүүлэлт	2018 I-VII	2019 I-VII	2020 I-VII *
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Уул уурхайн бүтээгдэхүүн	84.9	84.1	84.5
Барилгын материал	8.2	8.9	8.9
Мод, модон материал	0.5	0.6	0.5
Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн	1.1	1.0	0.9
ХАА-н гаралтай бүтээгдэхүүн	1.0	1.5	1.0
Хар төмөр (хаягдал, рельс г.м)	1.0	1.4	1.6
Бусад	3.3	2.5	2.6

Төмөр замын тээврээр 2020 оны эхний 7 сард тээсэн нийт ачаанд уул уурхайн бүтээгдэхүүн 84.5 хувь, барилгын материал 8.9 хувь, хар төмөр 1.6 хувь, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн 1.0 хувь, хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн 0.9 хувь, мод модон материал 0.5 хувь болон бусад бүтээгдэхүүн 2.6 хувийг эзэлж байна

### Төмөр замын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар



Төмөр замын тээврээр зорчигчид 2020 оны эхний 7 сард 1.1 (давхардсан тоо) сая болж, өмнөх оны мөн үеэс 398.5 (25.9%) мянган хүнээр буурсан байна.

Төмөр замын тээврээр зорчигчид буурахад орон нутгийн зорчигчид 344.1 (23.3%) мянган хүнээр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврээр зорчигчид 2020 оны 7 дугаар сард 254.5 (давхардсан тоо) мянга болж, өмнөх сараас 71.9 (39.4%) мянган хүнээр өссөн байна.


Төмөр замын тээврийн орлого 2020 оны эхний 7 сард 437.8 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 36.0 (8.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүн, тухайлбал төмрийн хүдэр, жонш, нүүрсний тээвэрлэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврийн орлого 2020 оны 7 дугаар сард өмнөх сараас 7.5 (11.6%) тэрбум төгрөгөөр өсөж, 71.7 тэрбум төгрөг болжээ.

### АГААРЫН ТЭЭВЭР

Агаарын тээврээр 2020 оны эхний 7 сард 1.6 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.6 (50.9%) мянган тонноор буурсан байна.

Агаарын тээврээр тээсэн ачаа, тонн, сараар




Агаарын тээврээр 2020 оны эхний 7 сард дотоодод 42.5 (2.7%) тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 3.8 (8.2%) тонноор буурсан байна.

Мөн олон улсад тээсэн ачаа 1.5 (97.3%) мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.6 (51.6%) мянган тонноор буурчээ.

Агаарын тээврээр тээсэн ачаа 2020 оны 7 дугаар сард 157.0 тонн болж, өмнөх сараас 52.0 (49.5%) тонноор өссөн байна.

Агаарын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар



Агаарын тээврээр зорчигчид 2020 оны эхний 7 сард 324.0 мянга (давхардсан тоогоор) болж, өмнөх оны мөн үеэс 553.9 (63.1%) мянган хүнээр буурсан байна. Агаарын тээврээр зорчигчид 2020 оны 7 дугаар сард 32.8 мянга болж, өмнөх сараас 8.9 (37.3%) мянган хүнээр өссөн байна.

Агаарын тээврээр орон нутагт зорчигчид 2020 оны эхний 7 сард 182.1 (56.2%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 63.1 (25.7%) мянган хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Чойбалсан чиглэлийн зорчигчид 87.3 хувь, Овоот чиглэлийн

зорчигчид 84.4 хувь, Мөрөн чиглэлийн зорчигчид 63.9 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр олон улсад зорчигчид 2020 оны эхний 7 сард 141.9 (43.8%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 490.8 (77.6%) мянган хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Улаанбаатар-Бээжин чиглэлийн зорчигчид 89.2 хувь, Улаанбаатар-Эрхүү чиглэлийн зорчигчид 85.2 хувь, Улаанбаатар- Хайлаар чиглэлийн зорчигчид 82.6 хувь, Улаанбаатар-Гонконг чиглэлийн зорчигчид 81.5 хувь, Улаанбаатар-Москва чиглэлийн зорчигчид 81.3 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2020 оны эхний 7 сард 80.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 199.0 (71.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2020 оны 7 дугаар сард өмнөх сараас 1.9 (23.7%) тэрбум төгрөгөөр өсөж 10.1 тэрбум төгрөг болсон байна.